



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн **Сувилагчийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтний** түр ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Гүйцэтгэх үүрэг:

- Сувилагчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгоход шаардагдах багц цагийг баталгаажуулах,
- Багц цаг биелүүлэн зөвшөөрөл сунгуулах сувилагчийн материалыг цахим болон үндсэн материалаар хүлээн авч хянан шийдвэрийг тухай бүр үйлчлүүлэгчид хүргүүлэх
- Сувилагчийн багц цагийн бүрдүүлэлтэд хяналт-үнэлгээ, судалгаа хийж тайлан мэдээ гаргах
- Сувилагчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн мэдээний сан үүсгэх, баяжуулах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах

Тавигдах шаардлага:

- Сувилахуй, анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд судлалын мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх
- Шударга, ёс зүйтэй, хариуцлагатай, зарчимч байх
- Эерэг харилцаа, хандлагатай байх

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет
- Их дээд сургууль төгссөн мэргэжлийн дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулах)
- Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- 3x4 цээж зураг - 2%

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэдийн материалыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж-13Б)-ийн 1 дүгээр байр, 2 давхар, 203 тоот өрөөнд 2022 оны 11 сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд хүлээн авна. Утас: 70128805

ЗАХИРГАА, САНХҮҮ, УДИРДЛАГЫН АЛБА

2022.10.20